

**Л. ЭРДЭНЭЧИМЭГ**

Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн эчнээ
5521 дүгээр
дамжааны сонсогч

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА ТӨВ ЭМНЭЛГИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

ШШГЕГ-ын харьяа төв эмнэлгийн уламжлал, чиг хандлагаас авч үзвэл:

1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр ардын намын төв хороо, Түр Засгийн газрын хамтарсан хурал болж төрийн яамдыг шинэчлэн байгуулахад Шүүх яамны ерөнхий хэлтсийн харьяанд "Гяндан салаа"-г байгуулжээ.

1943-1944 оны үед Төв лагерийн эмнэлэг нь дарга 1, аптекийн эрхлэгч 1, амбулаторийн эрхлэгч 1 орон тоотой, 35 ортой үйл ажиллагаагаа эхэлжээ. Тухайн үедээ дунд, дээд мэргэжилтэй хоригдлыг эмнэлгийн эмчээр ажиллуулдаг байсан ба дэлхийн 2 дугаар дайны хүнд үед хоригдлын ахуй хангалт доройтож, ганц удаа чанар муутай хоол бага хэмжээгээр идэх болсноор тураалд орох, эмнэлгийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломжгүй болсон. Харин 1946 оноос эмнэлгийн орон тоо нэмэгдэж больниц, амбулатори, мөрдөн, гяндан хариуцсан 3 бага эмчтэй болсны дээр өвчтний хоолонд I, II гурил, шар, цагаан будаа, элсэн чихэр, масло, жимс зэргийг олгодог болсноор сайжирсан байна.

Төв лагерийн эмнэлэг нь 1948 оноос эхлэн засан хүмүүжүүлэх газрын

эмнэлэг болж өөрчлөгдөж, орны тоо 40-50, 1960 онд 50 ортой болж нийт 51 төрлийн өвчтэй 32646 хоригдлыг амбулаториор, 1712 хоригдлыг больницоор эмчилгээ хийсэн байна. Тухайн үед хөдөөгийн хорих ангийн хоригдлыг өвчилсөн тохиолдолд тухайн аймгаас эмч дуудан үзүүлдэг байжээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1956-1995 оны хооронд 9 удаагийн гаргасан Засгийн газрын тогтоолоор ял эдлүүлэх байгууллагын эмнэлгийн нөхцлийг сайжруулах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орны тоог нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг өөрчлөх, нүүлгэн шилжүүлэх, эмч, эмнэлгийн багаж хэрэгслээр хангахад чиглэсэн олон арга хэмжээ авахаар заасны дагуу тодорхой ажил хийгдэж байжээ.

Хорих ял эдлүүлэх байгууллагын эмнэлгийн үйл ажиллагаа нь бүхэлдээ ердийн болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмч мэргэжилтнээр хангах, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, эм, эмнэлгийн багаж хэрэгслийн хүрэлцээг сайжруулахад чиглэгдэж ирсэн юм. Тухайн үед Хорих ял эдлэгсдийн өвчлөл их, үүнээс гадна хөдөлмөрийн осолд орсноос болж тахир дутуугийн зэрэлэл тогтоолгох явдал их байна.

Засан хүмүүжүүлэх байгууллагын төв, хөдөөгийн эмнэлгийн албыг бэхжүүлэх, эмч, мэргэжилтнээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулсны дүнд 1982 оны сүүлч гэхэд Төв эмнэлэг нь дотор, мэс засал, сүрьеэ, халдвартын тасагтай, 120 ортой болж өргөжсөн байна. Энэ үед тус эмнэлэгт 20 гаруй их эмч, 10 гаруй сувилагч, лаборант ажиллаж байв.

Үүний зэрэгцээ хөдөөгийн колониуд тус бүртээ хоригдлыг хэвтүүлэн эмчлэх 10-аас доошгүй ортой тасаг, их, бага, эмчтэй болж ажиллах орчин нөхцөл сайжирч ирсэн байна.

ШШГБ-ын Төв эмнэлэг нь аймгуудын эмнэлгийн, хорих ангиудын эмнэлэг нь сумын дундын эмнэлгийн зэрэглэлээр үйл ажиллагаагаа шаардлагын түвшинд амжилттай явуулж 2006 онд Монгол Улсын Эрүүл мэндийн ямаар магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсон.

Төв эмнэлгийн өнөөгийн байдлаар 4 тасаг нэгжтэй, 120 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2015 оны эхний улирлын байдлаар 22 их эмч, 17 сувилагч, тусгай мэргэжилтэн, 10 гаран үйлчилгээний ажилтан нийт 58 эмч, эмнэлгийн ажилтан албан хаагч ажиллаж байна.

ШШГЕГ-ын харъяа хот хөдөөгийн төвлөрсөн бүх хорих ангиудын ялтнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, өвчнийг эрт үед нь оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, ялтан бүрд хүрч үйлчлэх зорилготой байсан.

Зорилтууд:

1. Монгол улсын стандарт "MNS 5095-2001", Түгээмэл үйлдлийн стандарт MNS 4621-2008", Монгол улсын эрүүл мэндийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, болон бусад хууль журам тушаалуудын холбогдох заалтуудыг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулах.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үзүүлэх, өвчнийг эрт үед нь оношлох, эмчлэх.
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад эмч, эмнэлгийн

мэргэжилтний мэдлэг мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, сургалтанд хамруулах, эрдмийн зэрэг цолтой эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлж, орон тоогоор нь ажиллуулах, хүн хүчний нөөцийг зөв оновчтой хувиарлах.

4. Тасаг нэгжүүдийг бүтэц стандартын дагуу зохион байгуулах, эмнэлгийн тохижилт үйлчилгээг сайжруулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих эмч эмнэлгийн ажилчдын ажиллах хөдөлмөр ахуйн нөхцлийг сайжруулах.

5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын эмнэлгийн салбарт мөрдөгдөх хууль тогтоомж эрх зүйн актуудыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ өөрийн байгууллагын онцлогт тохирсон журмуудыг боловсруулах.

6. Эмнэлгийн багаж тоног төхөөрөмж техник хэрэгслийг хүчин чадлаар нь бүрэн ашиглах мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, дотоод сүлжээг суурилуулж, ашиглах.

Боловсролын байдлаар нь авч үзвэл:

МУ-ын зөвлөх, АШУ –ны доктор 1, тэргүүлэх зэрэгтэй эмч 1, магистр 4, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч 12, резидентур эмч 3, бакалавр сувилагч 5, мэргэшсэн сувилагч 6, дипломын сувилагч 10 байна.

2013-2015 онд ТГГ-н нэгдсэн эмнэлгээс хоригдогсдод үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ болон хийж гүйцэтгэсэн ажлууд:

ТГГ-ын нэгдсэн эмнэлэг нь 2013 оноос одоог хүртэл эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал боловсон хүчин сургалт мэдээдэл эмнэлгийн засвар тохижилтын ажил, шинэ багаж тоног төхөөрөмж, ялтнуудыг урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж ирсэн.

Үүнд 2013 онд ТГГ-аас системийн хэмжээний хорих анги эмнэлгийн ажилчдад зориулан "Байгууллагын тусламж үйлчилгээний стандарт, удирдамж, "Зонхилон тохиолдох өвчний эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж" 2013 гэсэн ном тохимол хэвлүүлэн гаргасан.

ТГГ-ын нэгдсэн эмнэлээс Хорих анги, Цагдан хорих төвийн болон тусгай мэргэжилтнүүдийн эмнэлгийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах журам түүний хавсралтыг боловсруулсан.

ШШГЕГ-ын харъяа эмнэлгийн албадын шатлал, зэрэглэл үйлчлэх хүрээлээр нь байгууллагын онцлогт тохируулан эмнэлгүүдийн бүтэц үйл ажиллагааны стандарт удирдамжийг улсын жишигт нийцүүлэн боловсруулж стандарт хэмжил зүйн төвөөр баталгаажуулсан.

Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ялтнуудын өвчлөлийн судалгааг доорхи хүснэгтээр харуулав.

№	Өвчний жагсаалт	2012 он	2013 он	2014 он
1	Амьсгалын эрхтэн систем	327	321	219
2	Хоол боловсруулах эрхтэн систем	419	456	411
3	Бөөр шээс ялгаруулах эрхтэн систем	427	439	345
4	Арьсны өвчин	78	62	24
5	Зүрх судасны өвчин	397	415	433
6	Дотоод шүүрлийн өвчин	38	52	58
7	Хавдар	12	8	5
8	Яс үе мөч булчингийн холбогч эдийн эмгэг	74	83	34
9	Мэдрэлийн тогтолцооны эмгэг	569	723	733
10	Мэс заслын эмгэгүүд	111	106	582
11	Бусад эмгэг	130	118	44
	Нийт	2519	2760	2888

ТГГ-ын нэгдсэн эмнэлгийн өвчлөлийн судалгаа:

2014 онд нэгдсэн эмнэлэг нь ХӨСҮТ-н сүрьегийн танадалт судалгааны ажлын эмч мэргэжилтнүүдтэй хамтран сүрьегийн эмчилгээнд хамрагдсан хоригдогчдын эмчилгээний дараах хяналтыг хорихын сүрьегийн эмнэлэгт хийх журмыг боловсруулан гаргасан.

Мөн ялаас чөлөөлөх өвчлөлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулан гарагсан. Европын Холбооны Swons сангийн шугамаар Швейцар улсын Skanes их сургуулийн эмч нарын баг нэгдсэн эмнэлэгт ажиллах хугацаандаа өвчтөнүүдэд цөсний чулуу, бэлэг эрхтнээс гадны биет авах, ивэрхийн уут нөхөх зэрэг хагалгаануудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Хорих ангиас эмчлүүлэхээр ирсэн өвчтөнүүдийг шаардлагатай тохиолдолд 3 дугаар шатлалын эмнэлэгт онош тодруулах болон хэвтэн эмчлүүлэх зорилгоор гаргадаг. Үүнд нэг эмч, 3-4 харуул хамгаалалтын ажилтан дагалдан явдаг.

Бусад энгийн эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөнтэй харьцуулахад ялтны сэтгэл зүйн онцлог нь хурдан эмчлүүлж эдгэрэх бус аль болох олон хоног хэвтэхийг эрмэлздэг нь ор хоногт сөргөөр нөлөөлж байдаг. Иймд хорих ангиудын эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор эмч мэргэжилтэн, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлэснээр төв эмнэлгийн ачаалал буурч ялтанд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжрах юмаа.

Одоогийн байдлаар төв эмнэлэгт ашиглагдаж байгаа тоног

төхөөрөмж багаж хэрэгсэлүүдийг эмчилгээний чиглэлээр нь авч үзвэл:

- Физик эмчилгээний кабинетийн тоног төхөөрөмж
- Биеийн тамир эмчилгээний кабинетийн тоног төхөөрөмж
- Дүрс оношлогооний \ рентген, ЭХО, ЗЦБ, ЭЭГ Дуран \
- Ариутгалд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж
- Клиник лабораторийн багаж тоног төхөөрөмж
- Мэс заслын тасгийн багаж тоног төхөөрөмж
- Шүдний кабинетийн багаж тоног төхөөрөмж
- Хүлээн авахад хэрэглэгддэг багаж тоног төхөөрөмжүүдийг эмчилгээнд ашиглаж байна.

Эдгээр оношлогооний аппарат багаж хэрэгслийн 20% нь 1972 – 2000 он, 80% нь 2001 оноос өнөөг хүртэл хэрэглэгдэж байгаа бөгөөд зарим багаж тоног төхөөрөмж нь орчин үеийн наад захын шаардлагын бүрэн хангахгүй байгаагаас оношлогоо, эмчилгээ, ор хоног ажлын бүтээмжинд сөргөөр нөлөөлж байна.

Цаашид төв эмнэлэг нь 2 дугаар шатлалын эмнэлгийн стандартаар ажиллахын тулд дор хаяж 8 тасаг нэгжтэй, стандартад нийцсэн барилга байгууламжтай болохын зэрэгцээ үүнийг дагаж орон тоо бүтэц нэмэгдэж, ажлын байр шинээр бий болох, эмчилгээ оношлогооний сүүлийн үеийн багаж тоног төхөөрөмжийн жагсаалтын гаргаж ШШГЕГ-т санал оруулсан. болох ба төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудаар хангагдах болно.

Мөн эмч, эмнэлгийн ажилчдын ажлын байран дахь эрх зүйн байдал

дээшилж эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүрдэнэ.

Улмаар нэг эмчлүүлэгчдэд тавих хяналт сайжирч эмчилгээ, сувилгааны чанар хүртээмж нэмэгдэж, цаашид бие даан асуудлаа шийдвэрлэх бүрэн чадамжтай болох юм.

Нэгдсэн эмнэлэг болон хот хөдөөгийн хорих ангийн эмнэлгийн ажилтнуудыг орон тоогоор нь бүрэн гүйцэд ажиллуулах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд урамшууллын хөшүүрэг бий болгох.

Дүгнэлт:

ТГГ-ын нэгдсэн эмнэлгийн өнөөгийн байдлаас харахад барилга байгууламж нь хуучирч хана таазанд нь ан цав цууралт өгсөн сантехник муудсан нь МУ-н Үндсэн хуульд зааснаар эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах эрхийг зөрчиж байна.

Мөн эмнэлгийн нэг хүнд ноогдох ажлын ачаалал нь бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг энгийн эмнэлгүүдтэй харьцуулахад эрс ялгаатай, эмнэлгийн ажилтанууд сэтгэл зүй, бие бялдрын хувьд дарамттай өндөр ачаалалтай, хаагдмал орчинд ажилладаг тул нийгмийн асуудал бусад хангамжийг тусгайлан авч үзэх шаардлагтай төдийгүй эмчилгээ болон эдийн засгийн орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна.

3 дугаар шатлалын эмнэлэгт өвчтөнүүдийг гаргаж эмчлүүлэх онош тодруулах хэвтэх явдал нь 1-4 хүний ажлын алдагдуулах буюу, 24 цагийн үүрэг гүйцэтгэсэн харуул хамгаалалтын ажлтныг илүү цагаар ажиллуулж хөдөлмөрийн хуулийг зөрчих, мөн төсөвлөгдөөгүй зардал мөнгө их зарцуулагдаж байдаг.